

Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га ойн төглийн талбайд Мод үржүүлгийн зориулалттай 3 ширхэг 6х20 м хүлэмж нийлүүлэх ажил

Байгууллага:	Хүүхдийг Ивээх Сан ТББ
Төслийн нэр:	Ойн төгөл бүтээгч хүүхдүүд
Байршил, хэмжээ:	Налайх Дүүргийн 5-р хороонд байрлах 5 га
Ажлын зорилго:	Хүлэмж худалдан авах
Төсвийн шугам:	1.1.3
Хугацаа:	2025.05.1 – 2025.05.30

1. Үндэслэл

ХИС нь 2024 оны 08 сараас эхлэн Налайх дүүрэгт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад иргэд, хүүхэд багачуудын оролцоотойгоор ойжуулах, ногоон орчныг бий болгох зорилготой “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийн зорилго нь Налайх дүүргийн зорилтот бүсэд мод тарих, хүүхэд, залуучуудын дунд уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг мэдээллийг түгээж, мэдээлэл, сурталчилгааны аяныг өрнүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилгод хувь нэмрээ оруулах юм. Төслийн үйл ажиллагааны үр дүнд орон нутгийн иргэд, хүүхэд, залуучууд уур амьсгалын өөрчлөлтийг сөрөх, тэсвэрлэх, дасан зохицох мэдлэг, ур чадвартай болно.

2. Хүлэмж худалдан авах зорилго

Төслийн 5 га талбайд тарьц, суулгац бойжуулах, бэлтгэх зорилгоор мод үржүүлгийн зориулалтаар ашиглах 6х20 хэмжээтэй 3 ширхэг хүлэмжийг худалдан авах, газар дээр нь тээвэрлэн хүргэх, бүрэн угсарч хүлээлгэн өгнө.

3. Гүйцэтгэх ажил, нийлүүлэлтийн хүрээ

Нийлүүлэгч дараах ажлуудыг бүрэн гүйцэтгэнэ:

- 6 метр өргөн, 20 метр урт хэмжээтэй нийт 3 ширхэг хүлэмжийг нийлүүлэх,
- MNS 6636:2026 стандартын шаардлага хангасан зуны нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх,
https://estandard.gov.mn/website/masm/standards_details.aspx?code=688ae741-28c9-4ee7-9ca0-66ea1bf18130
- Хүлэмж бүрд хаалга, агааржуулагч цонх, дотор чийг хадгалах систем суурилуулах боломжтой байх,
- Хүлэмжийн иж бүрдэл бүрэн (бэхэлгээ, утас, холбох хэрэгсэл г.м) байх,
- Хүлэмжийг зориулалтын газарт угсарч суурилуулах, газар дээр ажиллах ажилчид, хэрэгслийг хангах,
- Хүлэмжийг хүргэх, тээвэрлэх, угсрах зардлыг үнийн саналд багтаасан байх,
- Нийлүүлсэн бүтээгдэхүүнд наад зах нь 1 жилийн баталгаа өгөх,
- Хүлээлгэн өгөх үед богино зааварчилгаа өгөх,